

Сэдэв 5. Санхүүгийн төлөвлөлт, төсөвлөгдсөн санхүүгийн тайлан бэлтгэх нь

П.Жаргалтуяа /Доктор(Ph.D.), профессор/



Агуулга:

1. Санхүүгийн бүртгэл, тайлагнал
2. Санхүүгийн төлөвлөлт
3. Төсөвлөгдсөн санхүүгийн тайлан бэлтгэх
Дасгал ажил, кейс

1. Санхүүгийн бүртгэл, тайлагнал

1. Санхүүгийн бүртгэлийн тухай ойлголт

- Мэдээлэл хэрэглэгчид
- Санхүүгийн тайланг үнэн, зөв тайлагнах үүрэг

2. Санхүүгийн байдлын тайлан /Balance sheet/

3. Орлогын дэлгэрэнгүй тайлан /Income statement/

4. Өмчийн өөрчлөлтийн тайлан /Statement of stockholders equity/

5. Мөнгөн гүйлгээний тайлан /Statement of cash flows/


Нэмэлт тодруулга /Notes to accounts/

1. Санхүүгийн бүртгэлийн мэдээлэл, хэрэглэгчид

Мэдээлэл хэрэглэгчдийг 2 ангилна.

- **Гадаад мэдээлэл хэрэглэгчид:** Татварын байгууллага, нийгмийн даатгалын байгууллага, үнэт цаасны хороо, хөрөнгийн бирж, үйлдвэрчний эвлэл /Төрийн болон орон нутгийн байгууллага/, Хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчид /шууд харилцаатай байгууллага/ худалдан авагчид, нийлүүлэгчид
- **Дотоод мэдээлэл хэрэглэгчид:** Удирдлага, менежерүүд, дотоод хяналтын ажилтан, дотоод аудиторууд, борлуулалтын ажилтан, бусад ажиллагсад

Бизнесийн үндсэн үйл ажиллагаа /The business activities of an entity/



1. Санхүүгийн байдлын тайлан /The statement of financial position/ /

- Санхүүгийн байдлын тайлан – Байгууллагын өнгөрсөн тодорхой хугацааны санхүүгийн байдал /хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч/ үнэ, цэнэ, чадавхийг харуулдаг
- **Хөрөнгө** гэдэг нь өнгөрсөн үйл ажиллагааны явцад бий болсон, байгууллагын эзэмшилд байгаа, ирээдүйд үр өгөөж өгөх нөөц юм. Хөрөнгийг хөрвөх чадвараар нь эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө гэж ангилна
- **Өр төлбөр.** Бизнесийн өнгөрсөн үйл ажиллагааны явцад үүссэн бусдын өмнө хүлээх санхүүгийн хариуцлагыг өр төлбөр гэнэ. Төлөгдөх хугацаагаар нь богино, урт хугацаат өр төлбөр гэж ангилна.
- **Эздийн өмч.** Өмчийн эздийн оруулсан хөрөнгийн хэлбэр, мөнгөн дүнг харуулна.

1.Нягтлан бодох бүртгэлийн үндсэн тэнцэл, хоёр талт зарчим
/Accounting equation/

Хөрөнгө = Өр төлбөр + Эздийн өмч

OR

Assets = liabilities + owners equity

Санхүүгийн байдлын тайлан–Нягтлан бодох бүртгэлийн
үндсэн тэнцэлийг дэлгэрүүлж харуулдаг

Дасгал ажил, кэйс:

- Туяа ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийлүүлэх “ABC” ХХК-г үүсгэн байгуулж, бизнес эхлүүлэв.
- Туяа 20X1-ний 7 сарын 1нд 100,000.0 ₮ хөрөнгийг бизнестээ оруулж, харилцах дансанд шилжүүлэв.

Санхүүгийн байдлын тайлан

“ABC” ХХК

20X1 оны 7 сарын 1-ний байдлаар

Хөрөнгө

МЯН.ТӨГ

Банкин дахь харилцах

100,000.0

Эздийн өмч

Туяа өмч

100,000.0

Бизнесийн ажил гүйлгээ

1. 20x1 оны 7 сард 5000.0 ₮ -н тоног төхөөрөмж худалдаж авч, 1000.0₮ төгрөгийг бэлнээр төлж, үлдсэн мөнгийг 90 хоногийн дараа төлөхөөр болсон. /7 сарын 2/
2. 7 сарын 3 нд 2000.0 ₮ -н бараа материалыг бэлнээр худалдаж авсан.
3. 7 сарын 4 нд 500.0 ₮ үнэтэй ноосон бүтээгдэхүүнийг 1000.0 ₮ -р борлуулсан.

Санхүүгийн байдлын тайлан
“ABC” ХХК
20Х1 оны 7 сарын 2-ний байдлаар

Хөрөнгө

мян.төг

Банкин дахь харилцах

99,000.0

Тоног төхөөрөмж

5,000.0

104,000.0

Өр төлбөр

Өглөгийн данс

4,000.0

Эздийн өмч

Туяа өмч

100,000.0

104,000.0

Санхүүгийн байдлын тайлан
“ABC” ХХК
20X1 оны 7 сарын 3-ний байдлаар

Хөрөнгө	МЯН.ТӨГ
Банкин дахь харилцах	97,000.0
Бараа материал	2,000.0
Тоног төхөөрөмж	<u>5,000.0</u>
Нийт хөрөнгө	<u>104,000.0</u>
Өр төлбөр	
Өглөгийн данс	4,000.0
Эздийн өмч	
Туяа өмч	<u>100,000.0</u>
Өр төлбөр, эздийн өмч	<u>104,000.0</u>

Санхүүгийн байдлын тайлан
“ABC” ХХК
20X1 оны 12 сарын 31-ний байдлаар

Хөрөнгө	МЯН.ТӨГ
Банкин дахь харилцах	98,000.0
Бараа материал	1,500.0
Тоног төхөөрөмж	5,000.0
<u>Нийт хөрөнгө</u>	<u>104,500.0</u>
Өр төлбөр	
Өглөгийн данс	4,000.0
Эздийн өмч	
Туяа өмч	100,000.0
Хуримтлагдсан ашиг	500.0
<u>Өр төлбөр, эздийн өмч</u>	<u>104,500.0</u>

1. Орлогын дэлгэрэнгүй тайлан /Income statement/

- **Орлогын дэлгэрэнгүй тайлан.** Тодорхой /өнгөрсөн/ хугацааны бизнесийн орлого, зардал, олз, гарз, бизнесийн үр дүнг нэгтгэн харуулна.
- *Орлого, олз* гэдэг нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгөтэй холбоогүй компанийн хөрөнгийн өсөлт эсвэл өр төлбөрийн бууралтын үр дүнд эздийн өмч нэмэгдэхийг хэлнэ.
- *Зардал буюу гарз* нь бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулсан хөрөнгө, хөдөлмөр, бусад нөөцийн өртөг юм.

1. Орлогын дэлгэрэнгүй тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Орлогын тайлан бэлтгэх 2 хэлбэр байдаг.

1. Нэг үе шатат орлогын тайлан. Энэ тайлан нь орлого, зардал, цэвэр ашиг, энгийн хувьцааны нэгжид ногдох ашиг гэсэн хэсгээс бүрдэнэ. Цэвэр ашиг, алдагдлыг тооцоход нэг л удаа хасах үйлдэл хийдэг тул нэг үе шатат гэж нэрлэсэн.

Цэвэр ашиг/ алдагдал = Нийт орлого – Нийт зардал

2. Олон үе шатат орлогын тайлан.

Орлогын дэлгэрэнгүй тайланд орлогыг дэлгэрэнгүй, зардлыг хураангуйлж тайлагнадаг учир орлогын дэлгэрэнгүй тайлан, олон үе шатат орлогын тайлан гэж нэрлэдэг.

1. Орлогын дэлгэрэнгүй тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

- **Борлуулалтын цэвэр орлого** = Борлуулалтын орлого – Борлуулалтын хөнгөлөлт, буцаалт – Борлуулалтын үнийн бууралт
- **ББӨ** = Бараа материал С1+ Худалдан авалт /ХА/ + Дотоод тээврийн зардал - Худалдан авалтын хөнгөлөлт - ХА-ын буцаалт - Бараа материал С2
- **Татварын өмнөх ашиг /ТӨА/** = Нийт орлого – Орлогын албан татвараас бусад нийт зардал

ББӨ - Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

1. Орлогын дэлгэрэнгүй тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

- **Нийт ашиг.** Борлуулалтын орлого – Борлуулалтын өртөг
- $T\Theta A = (НА + Түрээсийн\ орлого + Хүүний\ орлого + Ногдол\ ашгийн\ орлого + Эрхийн\ шимтгэлийн\ орлого + Бусад\ орлого) - бүх\ зардал + бусад\ ашиг - бусад\ алдагдал + Олз - Гарз$
- Татварын дараах цэвэр ашиг /алдагдал / = Татвар төлөхийн өмнөх ашиг - Орлогын татварын зардал
- **Орлогын татварын зардал:** 0-6 тэрбум албан тавар ногдуулах жилийн орлогод 10%, 6 тэрбумаас дээш бол 600.0 сая + 6 тэрбумаас дээших дүнгээс 25 %, 0-300.0 сая хүртэлх бол 1 %

Орлогын тайлан
“ABC” ХХК
20Х1 оны 12 сарын 31-ний байдлаар

Орлого:	МЯН.ТӨГ
Борлуулалтын орлого	12,000.0
Зардлууд:	
Цалин, хүүний зардал, засвар үйлчилгээ	9,000.0
Цэвэр ашиг /ТӨА/	3,000.0
Татварын зардал	3,00.0
Цэвэр ашиг/алдагдал	2,700.0

Орлогын дэлгэрэнгүй тайлан

Борлуулалтын цэвэр орлого	11,596,075.0
ББӨ	8,652,593.0
Нийт ашиг	2,943,482.0
Үйл ажиллагааны зардлууд	
Маркетинг борлуулалт	1,795,428.0
Зохион байгуулалтын зардал	8,746.0
Ерөнхий удирдлагын зардал	454,501.0
Биет бус хөрөнгийн хорогдол	2,135.0
Хүү, бусад зардал	20,609.0
Нийт үйл ажиллагааны зардал	2,281,419.0
Татварын өмнөх ашиг	662,063.0
Татварын зардал	215,963.0
Татварын дараах цэвэр ашиг	446,100.0

1. Өмчийн өөрчлөлтийн тайлан /Statement of stockholders equity/

- Компанийн хувьцаа эзэмшигчид өмчийн өөрчлөлтийн тайлангаас эздийн өмчийн бүтэц, бүрэлдэхүүн болон бизнестээ оруулсан хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн талаарх мэдээллийг авч болно. Компанийн эздийн өмч нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй.
 - *Хувьцаат капитал*
 - *Халаасны хувьцаа*
 - *Нэмж төлөгдсөн капитал*
 - *Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл*
 - *Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц*
 - *Эздийн өмчийн бусад хэсэг*
 - *Хуримтлагдсан ашиг*

Өмчийн өөрчлөлтийн тайлан
“ABC” ХХК

20X1 оны 12 сарын 31-ний байдлаар

Туяа өмч, эхний үлдэгдэл	100,000.0
/Туяа өмч, 1 сарын 1, 20x1 /	
Нэмэх нь: Цэвэр ашиг	2,700.0
Хасах нь: Ногдол ашиг	1,000.0
Хуримтлагдсан ашиг, эцсийн үлдэгдэл	1,700.0
Туяа өмч, эцсийн үлдэгдэл	101,700.0

1. Мөнгөн гүйлгээний тайлан /Statement of cash flows/

- Аж ахуйн нэгжийн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн өөрчлөлтийг харуулсан тайланг мөнгөн гүйлгээний тайлан гэнэ. Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлангуудыг аккруэл суурьт зарчмын дагуу бэлтгэдэг бол мөнгөн гүйлгээний тайланг мөнгөн сууриар бэлтгэдэг.

1. Мөнгөн гүйлгээний тайлан

- Мөнгөн гүйлгээний тайлан бэлтгэх үндсэн 2 арга байдаг
 1. Шууд арга /Мөнгөн суурьт арга/
 2. Шууд бус арга/Аккруэл суурьт арга/
- Мөнгөн гүйлгээний тайлан нь 3 үндсэн хэсгээс бүрдэнэ.
 1. *Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ*
 2. *Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ*
 3. *Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ*
- Мөнгөн гүйлгээний тайланг бэлтгэх шууд ба шууд бус аргын үед үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний хэсгийг ялгаатай бэлтгэдэг боловч дүн нь тэнцүү байна.
- Шууд ба шууд бус аргын үед хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ болон санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний хэсгүүд адилхан байна.

Мөнгөн гүйлгээний тайлан

“ABC” ХХК

20X1 оны 12 сарын 31

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:

Бэлэн мөнгөөрх борлуулалтын орлого 8,000.0

Үйл ажиллагааны зардалд төлсөн мөнгө (9,000.0)

Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (1,000.0)

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:

Тоног төхөөрөмж худалдаж авсан (5,000.0)

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (5,000.0)

Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:

Зээл авсан 3,000.0

Бусад санхүүжилт орлого 10,000.0

Ноогдол ашиг (1,000.0)

Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 12,000.0

Цэвэр мөнгөн гүйлгээ 6,000.0

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл 0

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл 6,000.0

Санхүүгийн байдлын тайлан
“ABC” ХХК
20Х1 оны 12 сарын 31-ний байдлаар

Хөрөнгө	мян.төг
Харилцах данс	6,000.0
Авлагын данс	10,500.0
Бараа материал	32,200.0
Тоног төхөөрөмж	60,000.0
Нийт хөрөнгө	108,700.0
Өр төлбөр	
Өглөгийн данс	7,000.0
<u>Эздийн өмч</u>	
Туяа өмч	100,000.0
Хуримтлагдсан ашиг	1,700.0
Эздийн өмч	101,700.0
Өр төлбөр, эздийн өмч	<u>108,700.0</u>

2. Санхүүгийн төлөвлөлт

Төлөвлөлтийн процесс, үндсэн 3 үе шат:

1. Хаана байгаагаа ойлгох
2. Хаашаа явахаа шийдэх
3. Яаж хүрэхээ төлөвлөх

2. Санхүүгийн төлөвлөлт

Төлөвлөлт гэдэг нь зорилготойгоо уялдуулан өмнөх үеийн үзүүлэлтэд тулгуурлан, ирээдүйн хийх зүйлээ цаг хугацаатай холбон тодорхойлж, шийдвэр гаргах үйл явц юм. Санхүүгийн төлөвлөлт нь бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төлөвлөх, эх үүсвэрийг зориулалтын дагуу хувиарлах, мөнгөнд хөрөнгөнд хяналт тавих зорилготой. Санхүүгийн төлөвлөлт нь:

1. Өмнөх үеийн үзүүлэлтэнд тулгуурлана.
2. Биелэгдэх боломжтой
3. Тооцооо судалгаан дээр үндэслэгдэх
4. Урт, богино хугацааны төлөвлөлт нь хоорондоо уялдаатай байх
5. Хууль тогтоомжид нийцэх

Санхүүгийн төлөвлөлт: Мөнгөн хөрөнгийн төлөвлөлт, Ашгийн төлөвлөлт

3. Төсөвлөгдсөн санхүүгийн тайлан бэлтгэх

Ашгийг төлөвлөнө. **Борлуулалтын хувиар тооцох** энгийн аргыг ашиглан ашгийг төлөвлөж болно.

Орлогын тайлангийн үзүүлэлтүүд:

- *Борлуулалт*
- *ББӨ*
- *Маркетинг, борлуулалтын зардал*
- *Ерөнхий удирдлагын зардал*
- *Хүүгийн зардал*
- *Бусад зардал*
- *Татварын зардал*
- *Татварын дараах цэвэр ашиг*

3.Төсөвлөгдсөн санхүүгийн тайлан бэлтгэх

Төсөвлөгдсөн орлогын тайланг бэлтгэхдээ өнгөрсөн жилийн санхүүгийн тайлан, ирэх жилийн борлуулалтын таамаглалд үндэслэнэ. Хялбарчилсан аргуудын нэг болох “**Борлуулалтын хувиар тооцох арга**”-г ашиглана. Борлуулалтын таамаглал хийж, хүлээгдэж буй борлуулалтын орлогыг тооцож, Борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, санхүүгийн зардлыг өмнөх жилийн борлуулалтын орлогод эзлэх хувиар тодорхойлно.

$$\text{Борлуулалтын орлогод эзлэх үйл аж. зардал} = \frac{\text{Үйл ажиллагааны зардал}}{\text{Борлуулалтын орлого}}$$

$$\text{Борлуулалтын орлогод эзлэх ББӨ} = \frac{\text{ББӨ}}{\text{Борлуулалтын орлого}}$$

3. Төсөвлөгдсөн санхүүгийн тайлан бэлтгэх

Төсөвлөгдсөн санхүүгийн байдлын тайланг бэлтгэхэд хамгийн түгээмэл хэрэглэгддэг аргуудаас тохируулах арга байдаг. Энэ нь боломжит зарим үзүүлэлтийг тодорхойлоод, үлдсэн бусад үзүүлэлтийг тооцоолон гаргана. Санхүүгийн тайланд шинжилгээ хийдэг харьцааны аргуудыг ашиглан тооцно. Төсөвлөж буй зардлаа тогтмол, хувьсах гэж тооцоолбол илүү бодит тооцогдоно.

"AAA" ХХК Төсөвлөгдсөн орлогын тайлан
2012 оны 12 сарын 31 өдөр

төгрөгөөр

№	Үзүүлэлт	2011 оны 12 сар 31	2012 оны 12 сар 31
1	А. Орлого:		
2	Борлуулалтын орлого (цэвэр)	800,000.0	1,040,000.0
3	Борлуулалтын өртөг	(200,000.0)	(260,000.0)
4	Нийт ашиг(алдагдал)	600,000.0	780,000.0
5	Хүүний орлого	200,000.0	200,000.0
6	Нийт ашиг, орлогын дүн	800,000.0	980,000.0
7	Б. Зардал:		
8	Борлуулалт, маркетингийн зардал	250,000.0	325,000.0
9	Ерөнхий ба удирдлагын зардал	150,000.0	150,000.0
10	Санхүүгийн зардал	80,000.0	104,000.0
11	Бусад зардал	140,000.0	168,000.0
12	Үндсэн бус үйл ажиллаганы олз, (гарз)		
13	Нийт зардал	620,000.0	747,000.0
14	В.Ашиг		
15	Татварын өмнөх ашиг	180,000.0	233,000.0
16	Татвар (10%)	18,000.0	23,300.0
17	Татварын дараах цэвэр ашиг	162,000.0	209,700.0

Борлуулалтын орлогыг 30 хувиар өсгөх таамаглал дэвшүүлсэн. Зарим өөрчлөгдөхгүй зардлыг тогтмолоор тооцно.

"AAA" компани

Төсөвлөгдсөн санхүүгийн байдлын тайлан
2012 оны 12 сарын 31

Хөрөнгө	2011	2012
Мөнгөн хөрөнгө	40,000.0	186,700.0
Авлага	50,000.0	65,000.0
Бараа материал	160,000.0	208,000.0
Эргэлтийн хөрөнгө	250,000.0	459,700.0
Барилга	450,000.0	450,000.0
Тоног төхөөрөмж	150,000.0	195,000.0
Эргэлтийн бус хөрөнгө	600,000.0	645,000.0
Нийт хөрөнгө	850,000.0	1,104,700.0
Өр төлбөр, эздийн өмч		
Өглөг	100,000.0	130,000.0
Цалингийн өглөг	50,000.0	65,000.0
Урт хугацаат банкны зээл	200,000.0	200,000.0
Нийт өр төлбөр	350,000.0	395,000.0
Хувьцаат капитал	250,000.0	250,000.0
Хуримтлагдсан ашиг	250,000.0	459,700.0
Эздийн өмч	500,000.0	709,700.0
Нийт өр төлбөр эздийн өмч	850,000.0	1,104,700.0

Баярлалаа. 😊